

МОНГОЛ. ХОККАЙДОГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Ч. Далай

Хүндэт индрээс мэндчилье. Би Алс Монгол улсаас хүрэлцэн ирлээ. Монгол Улс өнөөдөр Зүүн хойт Азийн улс оронтой өргөн хамтын ажиллагаагаа явуулах үйл явцыг идэвхтэй эхлээд байна. Цаг хязгаартай байгаа учраас би Та бүхэнд Монгол улсын өнөөгийн байдлын талаар товчхон танилцуулъя. Монгол улс бол ихээхэн өвөрмөц онцлогтой орон. Өргөн уудам нутагтай хэдий ч хүн амаар тийм ч олон биш. Засаг захиргааны 21 нэгжид хуваагддаг. Цаг уурын хувьд нэлээд эрс тэс эх газрын уур амьсгалтай. Хүний гар хүрээгүй унаган байгалиа харьцангуй үлдээж хоцорсон Улс юм. 25 сая орчим толгой малтай, аж үйлдвэр, зам тээвэр, харилцаа холбоо төдийлөн хөгжөөгүй, далайд гарцгүй ийм орон.

Манай улс цаашид хөгжил дэвшлээ түргэсгэхэд суурь болох давуулаг талуудтай, тухайлбал зохих хэмжээний байгалийн нөөц баялагтай, авсаархан эдийн засагтай зэргийг дурдаж болно. Аж үйлдвэр бага боловч бололцоогоороо хөгжиж, бүтээгдэхүүнээ ард түмний өргөн хэрэгцээнд нийлүүлж байна.

Хүнсний үйлдвэрийн тухайд мал аж ахуйн бүтээгдэхүүн ихтэй, нэлээд хэмжээний малтай, мөн цаашлаад газар тариалангаас авах үр тариа, хүнсний ногоогоор өөрийн хэрэгцээг бүрэн хангах боломжтой. Хүн амын боловсролын түвшин зэгсэн өндөр, цөөн бус мэргэжилтэй боловсон хүчинтэй болсон. Тэгээд бас дэлхийн хоёр том зах зээлийн дунд оршдоогоороо газар зүйн ашигтай нөхцөлтэй улс юм.

Монгол бол нүүдлийн мал аж ахуйн орон гэдгийг та нөхөд мэднэ. Энэ утгаараа Монгол орон хүн төрөлхтний нэгэн соёл иргэншлийг хамгаалах түүхэн үүргийг биелүүлж байгаа гэж хэлж болно. Түүхээс оноосон хариуцлагыг хүн төрөлхтний өмнө хүлээсэн гэсэн үг юм. Бид бүхний соёл иргэншлийн үндэс нь авч үзвэл нүүдлийн мал аж ахуй нь цорын ганц аж ахуй байсан, байсаар байна. Өөрөөр хэлбэл амьдралын энэхүү хэвшил нь экологийн цэвэр бүтээгдэхүүнийг боловсруулж, байгаль орчныг бохирдуулдаггүй, хаягдал гаргадаггүй, эрчим хүчийг дээд зэргээр хэмнэдэг амьдралын арга хэлбэр бөгөөд үүгээр бид байгаль орчинтойгоо харилцан тэтгэлцэх битүү хэлхээг үүсгэж байдаг юм.

Гэвч өнөөгийн нөхцөлд тулгамдсан асуудал ч бас байна. Энэ нь нүүдлийн соёл иргэншлийн өв уламжлалыг орчин үеийн технологи, аж үйлдвэрийн ололттой хэрхэн хослуулж авч явах вэ гэдэг асуудал юм. Түүнчлэн үйлдвэрлэлээ цааш хөгжүүлэхдээ байгаль орчиндоо хор хөнөөлгүй ямар хэлбэрийг хэрхэн сонгож авах вэ? гэдэг асуудал оршиж байна. Бид өнөөдөр Зүүн хойт Азийн улс оронтой харилцаа хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийг эрмэлзэж байна. Түүний дотор Орос, Хятад, Солонгос болон азийн хамгийн хөгжилтэй Япон улстай харил-

*Ч. Далай. ЗХАСТ-ийн захирал, академич

цаагаа бэхжүүлэн хөгжүүлэх нь манай улсын эрх ашиг мөн юм. Ялангуяа Япон улстай тогтоосон харилцаа холбоогоо төрөл бүрийн салбарт хөгжүүлэх нь бидний эрх ашигт бүрэн нийцнэ. Ингэх нь манай улсын эдийн засгийг хөгжүүлэхэд маш чухал хүчин зүйл болно гэж ойлгож илтгэж байна.

Бид Японтой харилцах харилцааг бэхжүүлэхийн чухлыг дахин онцлон тэмдэглэхийг хүсч байна. Ялангуяа Хоккайдотой тогтоосон харилцааг өргөтгөх нь чухал гэж үзэж байна. Яагаад гэвэл Монгол улс Хоккайдо хоёрт нийтлэг ижил төстэй зүйл их байна. Газар зүйн хувьд ойролцоо төдийгүй, мал аж ахуй эрхэлж, сүү цагаан идээ боловсруулдаг зэрэг талаараа ч ижил төстэй байна. Ийм талуудаа түшиглэн харилцан туслалцах хамтран ажиллах боломжтой гэж бодож байна. Тухайлбал хурдан морины арчилгаа маллагаа, сүү цагаан идээ боловсруулах талаар хамтран ажиллах боломж бүрэн байна.

Энэ симпозиум Хоккайдод нээгдсэнтэй холбогдуулан ХХI зууныг угтаж Зүүн хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагаа улам гүнзгийрэн хөгжинө гэдэгт найдаж байна. Мөн Монгол-Японы харилцааны тухайд ч энхтайван, найрамдал нөхөрлөлийн үндсэн дээр цаашид өргөжин хөгжинө гэж итгэж байна. Чингис хааны Монгол улсыг төлөөлөн энэхүү олон улсын хуралд оролцож байгаадаа баяртай байна.

АСУУЛТ

Идэ: — Монголын Далай багшаас асуух зүйл байна. Далай багшаас Монгол улсын ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төвд ямар судалгаа хийж байгааг тайлбарлан өгөхийг хүсье. Бас боловсролын салбарын солилцоо, хүн солилцоонд тохиолдож буй бэрхшээлийн тухай ярина уу?

Далай: — Монголд олон улсын асуудал судлалын хүрээлэн хэд хэд бий. Дорно дахин, олон улсын харилцааны хүрээлэн, Зах зээлийн хүрээлэн, Засгийн газрын дэргэдэх хүрээлэн гэх мэт олон судалгааны хүрээлэн төв бий. Манай хүрээлэн ч тэдний нэг юм. Эрдэм шинжилгээний ажилтны тоо цөөн боловч судалгааны агуулгын хувьд гол нь Хятад, Орос, өөрөөр хэлбэл Зүүн хойт Азийн бүс нутагт хамаарах асуудлыг голлон судалж байна. Одоогоор Японы холбогдолтой судлалыг 3 эмэгтэй, 2 эрэгтэй нийт 5 эрдэм шинжилгээний ажилтан хийж байна. Япон хэлээр чөлөөтэй ярьдаг ажилтан ч бий. Өөрөөр хэлбэл Японд суралцаж, япон хэлийг эзэмших зайлшгүй шаардлагатай хүмүүс юм. Эдгээр ажилтнууд японы талаар ялангуяа япон монголын харилцаа, хамтын ажиллагааны талаар судалгаа хийж, илтгэл, өгүүлэл бичиж нийтлүүлж байна.

Сүүлийн үед манай байгууллагын хувьд япон хэлний сургалт өргөжиж, 30-аад оюутан япон хэлээр хичээллэж байна. Энэ мэтчилэн бид өөрсдөө япон хэлийг суралцах, Япон улсад монгол хэлийг заах явдал ойрын чухал зорилт гэж үзэж байна.

Идэ: — Өөр нэг зүйл асууя. Одоо Хоккайдо-д Монголоос ирж суралцаж байгаа хэдэн хүн байгаа вэ?

— Далай: — Албан ёсны тоог одоогоор мэдэхгүй байгаа боловч, миний сонссоноор бол 7 хүн эрдэм шинжилгээний ажилтан нар ирж суралцаж байгаа гэнэ. Цубон багшийн ярьснаар хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг их чухалчилж байгаа тэгээд ч Хоккайдод ирж байгаа хүмүүс нь ихэвч-

лэн ХХААЯ-ны хүмүүс байдаг бололтой.

Идэ: — Үнэхээр цөөхөн гэж бодож байна. Монгол оюутны тоо цөөн байгаа хамгийн гол шалтгааныг Та юу гэж бодож байна, мөнгө санхүүгийн шалтгаан байна уу аль эсвэл өөр асуудал байна уу?

Далай: — Мэдээж эдийн засаг, санхүүгийн асуудал мөн. Нөгөө талаар Орос, Өмнөд Солонгосоос танайд ирэхэд ойрхон байгаа атал Монголын хувьд Хоккайдад хүрч ирэхэд маш их тойрч явж ирж байна. Энэ мэтчилэнгийн хол ойрын зайны асуудал их байна. Энэ нь хоёр талын хамтын ажиллагаанд ихээхэн саад бэрхшээл учруулж байна гэж боддог.

Идэ: — Хөдөө аж ахуйн асуудлын талаар хэд хэдэн хүн санал хэллээ. Симпозиумын хамгийн эхэнд Юу Вэйхань багш хөдөө аж ахуйн асуудлаар үг хэлсэн. Дээр өгүүлсэнчилэн Хятад улсын хөдөө аж ахуйд сүүлийн үед нэлээд асуудал тулгарч байна. Хувиараа эрхлэх аж ахуйг дэмжиж байгаа Хоккайдо нь энэ асуудлыг шийдвэрлэхэд ямар нэг байдлаар тус үзүүлж чадах болов уу гэж бодож байна.

Энэ талаар Юу багшийн саналыг сонсоё.

Юу: — Хятадын Зүүн хойт хэсэг болон Хоккайдогийн газар тариаланг харьцуулж үзэхэд газар тариалангийн хувьд Хоккайдогоос суралцах зүйл их байна. Хоёр талд харилцан суралцах зүйл байгаа гэж би бодож байна. Хятадад ардын коммун тарж, хувийн аж ахуй бий болсон боловч цаашид газар тариаланг хэрхэн эрхлэх вэ гэдэг асуудал өнөөдөр тулгараад байна. Тиймээс ч нутагтаа харьсны дараа ямар нэг зүйлийг хийхэд Хоккайдог үзсэн минь их тус болно гэж бодож байна. Засаг захиргааныхан болон дээгүүр албан тушаалынханд ч Хоккайдог үзэх нь их ач холбогдолтой гэж бодож байна.

Идэ: — Их баярлалаа. Далай багшид ч гэсэн хөдөө аж ахуйн асуудлаар санал байгаа байхдаа.

Далай: — Би бол хөдөө аж ахуйн талаар судалгаа хийдэггүй, түүхч хүн. Гэвч монголыг төлөөлж байгаа болохоор Цүбон багшийн хэлсэнчилэн бид нийтлэг салбараа хөдөө аж ахуйд олж, цаашид хамтран ажиллаж чадах болов уу гэж бодож байна. Хамтын ажиллагааны эхлэл нэгэнт тавигдаад байна. Хэдийгээр цөөн ч гэсэн Хоккайдогийн хөдөө аж ахуйг үзсэн монгол хүн байгаа, монголчуудын хувьд японы газар тариаланг их хүндэтгэн үздэг юм. ХААЯ-наас ирсэн хүмүүс Японд суралцаж очоод ихээхэн зүйл хийх бизээ. Тийм ч утгаар нь би Хоккайдод ихээхэн талархаж байна.

Идэ: — Бидний бодоход Монгол болон Хоккайдогийн хөдөө аж ахуйд ижил төстэй тал байж магадгүй, гэхдээ ялгаатай тал нь их байх гэж бодож байна. Тодорхой хэлбэл Хоккайдогоос чухам юу нь Монголд ашигтай гэж бодож байна, тухайлбал сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ашигтай байж чадах уу?

Далай: — Таны хэлж байгаачилан сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл хэрэгтэй. Тухайлбал үхэр, адууны хариулга гэх мэтээр ч харилцан туршлага солилцох нь маш ашигтай гэж бодно. Монголын хувьд энэ бол маш томоохон салбар мөн. Мэдээж үр тарианы салбар ч нэгэн адил юм.

«Зүүн хойт Азийн энх тайван найрамдал, хамтын ажиллагаа» олон улсын симпозиумын эмхэтгэл, х.29—35-р талаас орчуулсан.
Б. СЭРЖАВ